



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 26 өдөр

Дугаар 1/23

Хэрлэн сум

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6 дахь заалт, Барилга хот байгуулалтын сайдын 2017 оны 208 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол улсын 2018 оны төсвийн тухай хуулийн хавсралт дахь Төсвийн хөрөнгөөр 2018 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтын XII.1.44-Д Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт, ус зайлуулах шугам /Хэнтий, Нэрлэн сум/, XII.1.452-Д Цамхаг гэрэлтүүлэг /Хэнтий, Нэрлэн сум/-ын ажил төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах захиалагчийн эрхийг Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газарт шилжүүлсүгэй.

2. Эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж тайлагнахыг Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын дарга /Г.Болд/-д, Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Дэмбэрэлсайхан/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБЯМБА

Аймгийн Засаг даргын 2018 оны
01 дугаар сарын... өдрийн 1/15
дугаар захирамжийн хавсралт

МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2018 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ,
БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		төсөвт өртөг	2018 онд санхүүжих /сая.төг/
XII.1.44	Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт, у.с зайлуулах шугам /Хэнтий, Хэрлэн сум/	2018	2018	150	150.0
XII.1.45	Цамхаг гэрэлтүүлэг /Хэнтий, Хэрлэн сум/	2018	2018	64	64.0